



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/243

Мандалговь

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2021 оны
үйл ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмж
хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээ”-ний үнэлгээг нэгдүгээр, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажил сайжруулах зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гэрээг нэг жилээр байгуулж, хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцож ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргад даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100347

Аймгийн Засаг даргын
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
А/чз дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮНЭЛГЭЭ

№	Шалгуур үзүүлэлт	Боржгинмандал ӨЭМТ		Өлзийтмандал ӨЭМТ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Удирдлага, зохион байгуулалт, менежерийн манлайлал	62 оноо /75 буюу 18%/	Ажил сайжруулах шаардлагатай	72 оноо /85.7 буюу 21%/	Хангалттай
2	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	138 оноо /84.4 буюу 40%/	Хангалттай	142 оноо /86.8 буюу 41%/	Хангалттай
3	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	67 оноо /68.3 буюу 20%/	Хангалтгүй	69 оноо /69.9 буюу 20.2%/	Хангалтгүй
Ерөнхий үнэлгээ		78.0%	Ажил сайжруулах шаардлагатай	82.2%	Хангалттай

Дүгнэлт: Боржгинмандал өрхийн ЭМТөв 78.0 хувьтай “Ажил сайжруулах шаардлагатай”, Өлзийтмандал өрхийн ЭМТөв 82.2 хувьтай “Хангалттай” гэж үнэлэгдсэн байна.